

ХАВСРАЛТ С. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОЙМ

ГЧНШТ нь газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөлд хамааралтай бүх дэд төслүүд боловсруулах шаардлагатай ба илүү нарийвчлан нүүлгэн шилжүүлэлтийн боломжит нөлөөлөл, эрсдлийн ач холбогдолтой нийцүүлсэн байна.

А. Хураангуй

Энэ хэсэгт төслийн хамрах хүрээ, гол судалгааны үр дүн, туслалцаа мөн санал болгосон арга хэмжээний талаар товч мэдээлэл өгнө.

- i. Төслийн хамрах хүрээ
- ii. Гол судалгааны Үр дүн
- iii. Туслалцаа авах эрх
- iv. Санал болгож буй арга хэмжээ

Б. Төслийн тодорхойлолт

Энэхүү хэсгээр төслийн ерөнхий мэдээллийг өгч газар чөлөөлөлт, албадан нүүлгэн шилжүүлэлт, эсвэл аль алиныг нь төслийн бүрэлдэхүүн хэсгүүдэд тусган төслийн талбайг тодорхойлно. Мөн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийг зайлсхийх эсвэл багасгах хувилбаруудыг авч үзэн тайлбарлана. Тоон өгөгдөл бүхий хүснэгтийг оруулах ба эцсийн шийдвэрт үндэслэл гаргаж өгнө.

- i. Ерөнхий танилцуулга
- ii. Төслийн бүрэлдэхүүн хэсэг
- iii. Төслийн талбай
- iv. Авч үзэж буй хувилбарууд

В. Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн хамрах хүрээ

Төслийн болзошгүй нөлөөллийг хэлэлцэж, газар эсвэл төслийн бүрэлдэхүүн хэсэг болон үйл ажиллагааны нөлөөллийн бүсийн газрын зургийг оруулах; газар чөлөөлөх хамрах хүрээг (газрын зурагт харуулах) тайлбарлах бөгөөд энэ нь яагаад гол хөрөнгө оруулалтын төсөлд шаардлагатайг тайлбарлах; худалдан авсан эд хөрөнгийн нөхцөл, өртсөн хүмүүсийн гол нөлөөллийг нэгтгэх, болон олж авч болох аливаа нийтийн өмч эх үүсвэрийн дэлгэрэнгүй мэдээллийг гаргах

Г. Нийгэм, эдийн засгийн мэдээлэл, нөхцөл байдал

Энэ хэсэгт нийгмийн нөлөөллийн үнэлгээний үр дүнг тодорхойлох, хүн амын тооллого судалгаа бусад судалгааны үр дүн, мэдээлэлтэй ба/ хүйс, эмзэг байдал, болон бусад нийгмийн бүлэгт ангилсан мэдээлэл; үүнд: тогтоох, тодорхойлох мөн иргэд олон нийтийн нөлөөлөлд өртөх тоог гаргах; нөлөөлөлд өртсөн хүмүүс ба олон нийтийн нийгэм, соёл, эдийн засгийн үзүүлэлтүүдийг авч газар, хөрөнгийн худалдан авалтын болзошгүй нөлөөллийг харгалзан тайлбарлах; ядуу уугуул / эсвэл үндэстний цөөнх болон бусад эмзэг бүлгийн талаар төслийн нөлөөллийг хэлэлцэх; жендэрийн болон нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөл, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, нөлөөлөл, хэрэгцээ, эмэгтэйчүүдийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох.

Д. Мэдээллийн ил тод болгох, хэлэлцүүлэг ба оролцоо

Энэ хэсэг: Төслийн оролцогч талууд, нэн ялангуяа гол оролцогч талуудыг тодорхойлох; төслийн мөчлөгийн өөр өөр үе шатанд ашиглах зөвлөгөөн, оролцоо механизмын талаар тайлбарлах, төслийг таниулах үйл ажиллагаа, төслийн зураг төсөл боловсруулах үед нүүлгэн шилжүүлэлтийн мэдээлэл, оролцогч талууд татан оролцуулах бэлтгэлийг тайлбарлах, Нөлөөлөлд өртсөн иргэдтэй хийсэн (тухайн орон нутгийн олон нийтийг оролцуулах) зөвлөлгөөний үр дүнг нэгтгэх; асуудал хэрхэн үүссэн болон гаргасан зөвлөмжийг нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөнд тусгасан байгааг хэлэлцэх; нөлөөлөлд өртсөн иргэдтэй төслийг нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөний тодруулгыг батлах аливаа дараагийн төлөвлөгөө ил тод болгох арга хэмжээг оруулах; төлөвлөсөн мэдээллийг ил тод болгох арга хэмжээг тайлбарлах (мэдээллийн түгээх төрөл, түгээх аргыг багтаах) төслийн хэрэгжилтийн явцад нөлөөлөлд өртсөн иргэдтэй зөвлөлдөх үйл явц.

Е. Гомдол барагдуулах механизм

Энэ хэсэгт нөлөөлөлд өртсөн иргэдийн асуудал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх механизмыг тайлбарлах болно. Энэ журам нь нөлөөлөлд өртсөн иргэд болон хүйсийн байдалд хэрхэн хандахыг тайлбарлана.

Ё. Хууль эрх зүйн орчин

Энэ хэсэгт:

- i. Төсөлд хэрэглэх Монгол улсын хууль тогтоомж болон АХБ-ны бодлогын шаардлагын хоорондын зөрүүг тодорхойлох болон Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журмыг тайлбарлах; эдгээр ялгааг хэрхэн шийдвэрлэхийг хэлэлцэх;
- ii. гүйцэтгэгч байгууллага нь хууль эрх зүйн болон бодлогын амлалтаа нөлөөлөлд өртсөн иргэдэд тайлбарлах
- iii. хөрөнгийн үнэ, орлого болон амьжиргааны орлуулах үнэлгээ, нөхөн олговрын хэмжээг тогтооход ашигласан зарчим, арга зүй тусгах
- iv. нөхөн олговор, тусламж авах эрхийн шалгуур болон хэрхэн, хэзээ нөхөн олговор, тусламж олгохыг тогтоох;
- v. газар чөлөөлөх үйл явцыг тайлбарлах, гол үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцсэн хуваарийг бэлтгэх.

Ж. Эдлэх эрх, дэмжлэг, үр өгөөж

Энэ хэсэгт:

- i. Нөлөөлөлд өртсөн этгээдийн хуульд нийцэх байдал болон эдлэх эрхийг тодорхойлж, бүх нүүлгэн шилжүүлэлтийн туслалцаа үзүүлэх арга хэмжээг (туслалцааны матриц орно) тайлбарлах;
- ii. эмэгтэйчүүд болон бусад тусгай бүлэгт л үзүүлэх туслалцаа дэмжлэгийг нарийн зааж өгөх;
- iii. нөлөөлөлд өртсөн иргэдийн төслийн бүтээн байгуулалтаас зохих үр ашиг хүртэх боломжийг тусгах

З. Орон сууцыг шилжүүлэн байршуулах, суурьшуулах

Энэ хэсэгт:

- i. орон сууц болон бусад барилга байгууламж, орон сууцаар солих, бэлэн мөнгөөр

- нөхөн олговор авах ба эсвэл/ өөрөө сонгох (хүйсийн асуудал, эмзэг бүлэгт дэмжлэг үзүүлэх зэргийг тодорхойлсон байх) зэрэг шилжүүлэх хувилбаруудыг тайлбарлах
- ii. төлөвлөж буй өөр нүүлгэн байршуулах талбайг тайлбарлах; олон нийтийн зөвлөлгөөн зохион байгуулах, сонгосон талбайн үндэслэл, түүний дотор байршлын тухай дэлгэрэнгүй мэдээлэл, талбайн байгаль орчны үнэлгээ, хөгжлийн хэрэгцээ зэргийг багтаана.
 - iii. талбайг бэлтгэх, шилжүүлэх хуваарийг гаргах;
 - iv. нүүлгэн шилжүүлсэн иргэдэд эзэмших, шилжүүлэх түрээсийг тогтмолжуулах хууль эрх зүйн зохицуулалтыг тайлбарлах;
 - iv. нөлөөлөлд өртсөн иргэдэд туслан шинэ талбай дээр тэдний шилжүүлэх, суурьшуулах арга хэмжээг тусгах; болон
 - vi. иргэдийг дэд бүтцээр хангах төлөвлөгөөг тайлбарлах;
 - vii олон хүн амтай хүлээн авагч талын хүн амыг хэрхэн нэгтгэх тайлбарлах

И. Орлогыг нөхөн сэргээх

Энэ хэсэгт:

- i. амьжиргааны эрсдэл тодорхойлж, хүн ам зүйн мэдээ, амьжиргааны эх сурвалж дээр тулгуурлан задаргаатай хүснэгтүүдийг боловсруулах;
- ii. орлогыг нөхөн сэргээх хөтөлбөрийг тайлбарлах, үүнд амьжиргааны бүх төрлийг сэргээх олон хувилбарыг багтаах (жишээ нь төслийн үр ашгийг хуваах, орлогыг хуваах зохицуулалт, газар, тогтвортой байдал болон хангамжийн талаар хэлэлцэх гэх мэт хувь нийлүүлсэн хөрөнгийн хувь)
- iii. нийгмийн даатгал эсвэл төслийн тусгай сангаар хангамжаар хангах арга хэмжээг тодорхойлох
- iv. эмзэг бүлгийг дэмжих тусгайлсан арга хэмжээг тайлбарлах;
- v. хүйсийг авч үзэхийг тайлбарлах, мөн сургалтын хөтөлбөрийг тайлбарлах

Й. Нүүлгэн Шилжүүлэлтийн Төсөв ба Санхүүжилтийн Төлөвлөгөө

Энэ хэсэгт:

- i. нүүлгэн шилжүүлэлтийн нүүлгэн шилжүүлэлтийн нэгж, ажилтны сургалт, хяналт үнэлгээ болон зээлийн хэрэгжилтийн үеийн нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөний бэлтгэл зэргийг оролцуулан бүх үйл ажиллагаагааны тус бүрийн төсвийг бэлтгэн өгөх,
- ii. Санхүүжилтын урсгалыг тайлбарлах (жилийн нүүлгэн шилжүүлэлтийн төсвөөр зардлын гол төрлөөр төсөвлөсөн байдлыг харуулах шаардлагатай);
- iii. нөхөн төлбөрийн хэмжээ болон бусад зардлын тооцоолол, (биет болон үнийн магадлашгүй зардлын тооцоолол), нэмэлт нүүлгэн шилжүүлэх зардлын тооцоолол хийсэн бүх таамаглалын үндэслэлийг оруулах
- iv. нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөний төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрийн тухай мэдээллийг оруулах

К. Байгууллагын зохицуулалт

Энэ хэсэгт:

- i. нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөний авч хэрэгжүүлэх арга хэмжээ, байгууллагын зохицуулалт, үүрэг, механизмыг тайлбарлах;
- ii. байгууллагын чадавхийг сайжруулах хөтөлбөрийг багтаах, шаардлагатай бол техникийн тусламжийг оруулах

- iii. Хэрвээ хамааралтай бол нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөлт болон менежментэд нөлөөлөлд өртсөн иргэд, аж ахуйн нэгж болон ТББ гүйцэтгэх үүргийг тайлбарлах
- iv. нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөлт болон менежментэд хэрхэн эмэгтэйчүүдийг оролцуулахыг тайлбарлах

Л. Хэрэгжүүлэлтийн хуваарь

Энэ хэсэгт бүх нүүлгэн шилжүүлэлт болон шинэчлэлийн гол үйл ажиллагааны нарийвчилсан, тодорхой цаг хугацаа заасан хэрэгжилтийн төлөвлөгөөг багтаасан. Хэрэгжилтийн төлөвлөгөөг төслийн барилга угсралтын ажлын хуваарьтай нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааг зэрэгцүүлэн бүх талаар нь харуулсан ба газар чөлөөлөлтийн үйл явц болон хугацааг бэлтгэсэн.

М. Хяналт ба Тайлагнал

Энэ хэсэгт нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх, хянах төслийн тохиромжтой механизм мөн жишигийг тодорхойлсон ба нөлөөлөлд өртсөн иргэдийг хяналтын үйл ажиллагаанд оролцуулах зохицуулалтыг тусгайлан заасан. Мөн тайлагналтын журмыг тайлбарласан.